

Хэлэлцэх төсөл

Зээлийн дугаар \_\_\_\_ МОН(COL)

**МОНГОЛ УЛС**

болон

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ**

хоорондын

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР**

(Энгийн нөхцөл [хөнгөлөлттэй])

(Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо болон үйлчилгээг хангах төсөл)

ОГНОО \_\_\_\_\_

МОН 48076

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР**  
(Энгийн нөхцөл [хөнгөлөлттэй])

МОНГОЛ УЛС ("Зээлдэгч" гэх) болон АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ("АХБ" гэх) хооронд \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ -ны өдөр байгуулсан ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

ҮҮНД:

(А) Зээлдэгч нь энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хавсралт 1-т тусгасан төслийг хэрэгжүүлэх зорилгоор АХБ-наас зээл авах хүсэлт гаргасан;

(В) Энэхүү гэрээтэй зэрэг байгуулсан Зээлдэгч болон АХБ хоорондын буцалтгүй тусламжийн хэлэлцээр ("Буцалтгүй тусламжийн хэлэлцээр" гэх)-ийн дагуу, АХБ нь Ядуурлыг Бууруулах Японы Сан (ЯБЯС)-гаас олгож буй буцалтгүй тусламжийг ЯБЯС-гийн 2016 оны журамд заасан нөхцөл, болзлын дагуу удирдан хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн;

(С) Уг төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) хэрэгжүүлэх ба Зээлдэгч нь төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор энэхүү зээлийн хөрөнгийг АХБ-ны шаардлагад нийцсэн нөхцөл, болзлын дагуу ХНХЯ-нд гаргана;

(D) АХБ нь дор дурдсан нөхцөл, болзлын дагуу тус банкны энгийн хөрөнгийн нөөцөөс Зээлдэгчид хөнгөлөлттэй зээл олгохыг зөвшөөрсөн болно;

ИЙМЭЭС талууд доор дурдсаныг харилцан тохиролцов. Үүнд:

**НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ**

**Зээлийн зохицуулалт, нэр томъёо**

Заалт 1.01. АХБ-ны 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн Энгийн нөхцөл бүхий зээлийн журам ("Зээлийн журам" гэх)-ын бүх заалт энэхүү Зээлийн хэлэлцээрт бүрнээ тусгагдсаны нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Заалт 1.02. Зээлийн журамд тодорхойлсон зарим нэр томъёог энэхүү Зээлийн хэлэлцээрт өөрчлөн тодорхойлоогүй эсвэл тухайн нэг хэсэгт агуулгын хувьд өөр утга илэрхийлээгүй бол тэдгээр нь энэхүү Зээлийн хэлэлцээрт ижил утгаар хэрэглэгдэнэ. Дараах нэмэлт нэр томъёо нь дор дурдсан утгыг илэрхийлнэ.

(а) "Зөвлөх үйлчилгээний журам" гэж 2013 батлагдсан Азийн Хөгжлийн Банк болон түүний зээлдэгчид зөвлөх авч ажиллуулах тухай журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг;

(б) "Зөвлөх үйлчилгээ" гэж энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хавсралт 1-ийн 3-р хэсэгт тодорхойлсон зээлийн хөрөнгөөс санхүүжих үйлчилгээг;

- (в) “ХБХ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг;
- (г) “ХБИБ” гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагыг;
- (д) “БОМТ” гэж “Байгаль орчны анхны үнэлгээ”-ний хүрээнд төсөлд зориулан боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүнд орох нэмэлт өөрчлөлтийг;
- (е) “Байгаль орчны хамгаалал” гэж Хамгааллын бодлогын баримт бичгийн 5 дугаар бүлэг, хавсралт 1, болон хавсралт 4-т заасан (холбогдох) зарчим болон шаардлагыг;
- (ё) “ЖУАТ” буюу “Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж ХНХЯ болон АХБ-ны харилцан хүлээн зөвшөөрч төсөлд зориулан боловсруулсан жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөг;
- (ж) “Бараа гэж” энэхүү зээлийн хөрөнгөөр худалдан авах тоног төхөөрөмж, эд материал болон тээвэрлэлт, даатгал, суурилуулалт, шимтгэл, сургалт, эхэн үеийн засвар үйлчилгээг хэлнэ. Үүнд Зөвлөх үйлчилгээ хамаарахгүй;
- (з) “ОУУХА” гэж олон улсын үйл хөдлөлийн ангиллыг;
- (и) “БОАУ” буюу “Байгаль орчны анхны үнэлгээ” гэж Зээлдэгчийн бэлтгэн хүргүүлэн АХБ-аар хянан батлуулсан төслийн байгаль орчны анхны үнэлгээ, түүнд орох нэмэлт өөрчлөлтийг;
- (к) “Зээлийн зарцуулалтын гарын авлага” гэж 2015 онд батлагдсан АХБ-ны зээлийн зарцуулалтын гарын авлага, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг;
- (л) “ТХГА” буюу “Төсөл хэрэгжүүлэх гарын авлага” гэж [ ] -ний өдөр батлагдсан, Зээлдэгч болон АХБ-ны харилцан зөвшөөрсөн төсөлд зориулан боловсруулсан төсөл хэрэгжүүлэх гарын авлага болоод Зээлдэгч болон АХБ-ны холбогдох журамд нийцүүлэн түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг;
- (м) “ТХН” гэж төсөл хэрэгжүүлэх нэгжийг;
- (н) “Худалдан авах ажиллагааны журам” гэж 2015 онд батлагдсан АХБ-ны Худалдан авах ажиллагааны журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг;
- (к) “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” гэж Зээлдэгч болон АХБ харилцан тохиролцсон, [ ] -ний өдөр батлагдсан Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон Худалдан авах ажиллагааны журам, Зөвлөх үйлчилгээний журам болон АХБ-тай тохиролцсон бусад нөхцөлийн дагуу түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг;
- (о) “Төслийн гүйцэтгэгч байгууллага” гэж Зээлийн журмын зорилт, түүний агуулгын хүрээнд төслийг хариуцан хэрэгжүүлэх ХНХЯ, эсхүл түүний эрх, үүргийг залгамжлах АХБ-нд хүлээн зөвшөөрөгдөхүйц эрх бүхий байгууллагыг;

- (е) "Төслийн байгууламж" гэж төслийн хүрээнд шинээр барьж байгуулах, өргөтгөх з эсвэл/мөн засварлах барилга байгууламжийг;
- (п) "ХБИ" гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг;
- (р) "Хамгааллын хяналт шинжилгээний тайлан" гэж Зээлдэгчээс боловсруулан АХБ-нд хүргүүлсэн БОМТ-ний хэрэгжилт, даган мөрдөж буй үйл явц, зөрчлийг арилгах болон урьдчилан сэргийлэх, аливаа үйл ажиллагааны талаархи тайланг;
- (с) "Хамгааллын бодлогын баримт бичиг" гэж 2009 онд батлагдсан АХБ-ны хамгааллын бодлогын баримт бичгийг;
- (т) "Төгрөг" буюу "Төг" нь Зээлдэгчийн мөнгөн тэмдэгтийг; мөн
- (у) "Ажил" гэж зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилгын буюу барилга угсралтын ажил, түүнчлэн өрөмдлөгө, зураг төсөл боловсруулах болон нэг удаагийн шинжтэй, эсхүл түлхүүр гардуулах гэрээний хүрээнд гүйцэтгэх төсөлтэй холбоотой үйлчилгээг хэлнэ. Үүнд зөвлөх үйлчилгээ хамаарахгүй.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ

### Зээл

Заалт 2.01. (а) АХБ нь тус банкны энгийн хөрөнгийн нөөцөөс [SDR-ийн дүнг оруулах] Зээлжих тусгай эрх (SDR[\_\_\_\_\_])-тэй тэнцэх хөрөнгийг хэд хэдэн төрлийн валютаар [хорин таван сая ам.доллар (\$25,000,000).] {эсвэл} [зээлийн дүн болон валютыг тусгах: ам.доллар/иен/евро/фунт стерлинг] ((\$/JPY/€/£[\_\_\_\_\_])). Зээлдэгчид зээлэхийг зөвшөөрөв.

(б) Зээлийн үндсэн төлбөрийг төлөх хугацаа нь 20 жил байх ба энэхүү заалтын дэд хэсэг (с)-д тусгасанчилан үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаатай байна.

(в) Дээрх дэд хэсэг (б)-д заасан "үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа" гэж энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 2-т заасан зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу үндсэн зээлийг эргүүлэн төлж эхлэх анхны товлосон хугацаа хүртэлх үеийг хэлнэ.

Заалт 2.02. Зээлдэгч нь АХБ-нд зээлийн данснаас авч ашигласан зээлийн эргэн төлөөгүй үлдэгдэлд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа болон түүнээс хойшхи хугацаанд жилд 2%-ийн хүү төлнө.

Заалт 2.03. Зээлийн хүүгийн шимтгэл болон бусад төлбөрийг хагас жилээр жил бүрийн [ ] болон [ ]-ны өдөр тус тус төлнө.

Заалт 2.04. Зээлдэгч нь Зээлийн данснаас авч ашигласан

зээлийн төлбөрийг энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 2-т дурдсан зээлийг эргэн төлөх хуваарийн дагуу эргүүлж төлнө.

Заалт 2.05. Зээлийн журмын 4.3(а) болон 4.04 заалтын зорилгоор үндсэн зээл болон хүүгийн шимтгэлийг эргүүлэн төлөх валютын нэгж нь ам.доллар байна.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ

### Зээлийн хөрөнгийг ашиглах

Заалт 3.01. Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг энэхүү зээлийн хэлэлцээрийн заалтын дагуу, төслийн хүрээнд гарах зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

Заалт 3.02. Зээлийн хөрөнгийг энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 3-т заасны дагуу хуваарилж, зарцуулах ба Зээлдэгч, АХБ хоёр харилцан тохиролцсоноор уг хавсралтад тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Заалт 3.03. АХБ тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд Зээлдэгч зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлыг энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 4-т заасны дагуу худалдан авах буюу худалдан авах нөхцөлөөр хангана.

Заалт 3.04. Бараа, ажил, зөвлөх үйлчилгээг худалдан авахтай холбоотойгоор Зээлийн данснаас хийгдэх гүйлгээг зөвхөн дараах нөхцөлд хийнэ. Үүнд:

- (а) АХБ худалдан авах ажиллагааны эрх бүхий эх үүсвэр хэмээн тухай бүр тодорхойлсон гишүүн орнуудад үйлдвэрлэж, нийлүүлсэн бараа болон тэдгээр улсаас нийлүүлж гүйцэтгэх ажил, зөвлөх үйлчилгээг худалдан авахад; мөн
- (b) АХБ-аас тухай бүр тодорхойлон гаргасан эрх бүхий байх шаардлагыг хангасан бараа, ажил, болон зөвлөх үйлчилгээг худалдан авахад.

Заалт 3.05. Зээлийн журмын 8.02 заалтын зорилгоор зээлийг хаах өдөр нь 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр байх буюу эсвэл Зээлдэгч болон АХБ тухай бүр шинээр харилцан тохиролцсон бусад өдөр байна.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

### Тусгай нөхцөл

Заалт 4.01. Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх, төслийн барилга, тоног төхөөрөмжийг ашиглах явцад энэхүү зээлийн хэлэлцээрийн Хавсралт 5-д заасан бүх үүргийг биелүүлэх буюу биелүүлэх нөхцөлийг хангана.

Заалт 4.02. (a) Зээлдэгч нь (i) төслийн мөнгийг байршуулах тусгай данс нээх, бүртгэл хөтлөх; (ii) АХБ-наас хүлээн зөвшөөрсөн санхүүгийн тайлан бэлтгэх стандартын дагуу төслийн санхүүгийн тайланг жил бүр гаргах; (iii) уг санхүүгийн тайланд АХБ-наас хүлээн зөвшөөрхүйц аудитын стандартын дагуу, мэргэжлийн ур чадвар, туршлага болон ажлын даалгаврын хувьд АХБ-ны шаардлагыг хангах хөндлөнгийн, бие даасан аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэх; (iv) эдгээр аудит нэг бүрийн хүрээнд аудитороор санхүүгийн тайлан болон Зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаар дүгнэлт бүхий тайлан болон удирдлагын дүгнэлт (аудитын шалгалтын үеэр төслийн дотоод хяналтын талаар ямар нэг дутагдал илэрсэн бол түүнийг дурдсан) гаргуулах; (v) тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 6 сарын дотор аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын тайлан болон удирдлагын дүгнэлтийн хувийг англи хэл дээр бэлтгэж, АХБ-инд хүргүүлэх ба АХБ-ны хүсэлтээр эдгээр баримт бичиг, аудитын шалгалттай холбоотой бусад мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгнө.

(б) АХБ нь төслийн аудит хийсэн санхүүгийн жилийн тайлан болон уг тайлангийн талаарх аудиторуудын дүгнэлтийг тийнхүү шаардлагад нийцсэн хэмээн мэдэгдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор өөрийн цахим хуудаснаа байршуулна.

(в) АХБ төслийн санхүүгийн тайлан, төсөлтэй холбоотой санхүүгийн асуудлыг дээрх дэд хэсэг (a)(iii)-ын дагуу аудиторуудтай хэлэлцэх хүсэлтийг тавьсан тохиолдолд Зээлдэгч энэхүү боломжоор хангаж, ийм хэлэлцээний үед аудиторуудын төлөөллийг байлцуулах арга хэмжээ авна. Зээлдэгч өөрөөр тохирсноос бусад тохиолдолд хэлэлцээний үед Зээлдэгчийн эрх бүхий төлөөлөгч заавал байлцана.

Заалт 4.03. Зээлдэгч нь АХБ-ны төлөөлөгчдөд төсөл, бараа, ажил болон бусад холбогдох аливаа бичиг баримт, бүртгэлийг шалгах нөхцөлөөр хангана.

## ТАВДУГААР ЗҮЙЛ

### Хүчин төгөлдөр болох

Заалт 5.01. Доор дурдсан нөхцөл нь Зээлийн журмын Заалт 9.01(f)-ийн дагуу энэхүү зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болоход шаардагдах нэмэлт нөхцөл болно: Буцалтгүй тусламжийн хэлэлцээрийг хууль ёсны байгуулж, хүргүүлсэн байх ба уг хэлэлцээр хүчин төгөлдөр болоход шаардлагатай бүхий л нөхцөл (үүнд энэхүү зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болоход тавигдах нөхцөл хамаарахгүй) хангагдсан байна.

Заалт 5.02. Доор дурдсан зүйл нь Зээлийн журмын Заалт 9.02(f)-ийн дагуу энэхүү АХБ-нд ирүүлэх бичиг баримт эсвэл бичгүүдэд хавсаргах нэмэлт зүйл болно: Зээлдэгчийн өмнөөс Буцалтгүй тусламжийн хэлэлцээрийг зохих журмын дагуу баталж эсвэл соёрхон баталж, уг хэлэлцээр нь түүнд тусгасан болзлын дагуу Зээлдэгчид

хуулиар бүрэн үйлчлэх болсон байна.

Заалт 5.03. Зээлийн журмын 9.4 заалтын зорилгоор зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш 90 хоногийн дараа энэхүү зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

## **ЗУРГАДУГААР ЗҮЙЛ**

### **Бусад**

Заалт 6.01. Зээлийн журмын 11.02 заалтын зорилгоор Зээлдэгч талын төлөөлөгч нь Зээлдэгчийн Сангийн сайд байна.

Заалт 6.02. Зээлийн журмын 11.01 заалтын зорилгоор дараах албан ёсны хаягийг ашиглана. Үүнд:

#### Зээлдэгчийн хувьд

Сангийн яам  
Засгийн газрын байр II  
С.Данзангийн гудамж 5/1  
Засгийн газрын II байр  
Улаанбаатар-15160  
Монгол улс  
Факс: (976-51) 320247

#### АХБ-ны хувьд

Азийн Хөгжлийн Банк  
Азийн Хөгжлийн Банкны өргөн чөлөө 6  
Мандалуйонг хот  
1550 Метро Манила  
Филлипин Улс  
Факс: (632) 636-2444  
(632) 636-2407.

ЭНД ӨГҮҮЛСНИЙГ НОТЛОН, талууд зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчдөөрөө дамжуулан хэлэлцээрийн эхэнд дурдсан өдөр энэхүү зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурж, АХБ-ны Төв байранд хүргүүлнэ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

---

[Нэр, албан тушаал]

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

---

[Нэр, албан тушаал]



## ХАВСРАЛТ 1

### Төслийн тодорхойлолт

1. Энэхүү төслийн зорилго нь ХБИ-ийн үйлчилгээний хүртээмж болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болно.
2. Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

**Бүтээгдэхүүн 1: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэлтийг эрчимжүүлж, институтчилэх.** Төслийн хүрээнд (i) ХНХЯ-наас санаачилсан хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх одоогийн загварыг институтчилэх, мөн (ii) ирт илрүүлэлтэд оролцох хүмүүсийн ур чадварыг хөгжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлийг тогтоох эмнэлгийн аргачлалаас нийгмийн загварчлалд шилжихэд дэмжлэг үзүүлнэ.

**Бүтээгдэхүүн 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах.** Төслийн хүрээнд (i) эцэг эх-хүүхэд-багш гэсэн интерактив боловсролын загварыг сургуулийн өмнөх насныханд хэрэгжүүлэх; (ii) зургаан аймагт загвар бүхий ХБИ-ийн хөгжил, сэргээн заслын төвүүдийг байгуулах; (iii) хөдөлмөр болон хэл засал, хөдөлгөөн засал болон согог заслын (orthopedic) мэргэжилтэн, мөн нийгмийн ажилтанд зориулсан шинэ сургалтын хөтөлбөр боловсруулж нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх; (iv) ХБИ-ийг дэмжих нийгмийн ажилтнуудын үүрэг ролийг бэхжүүлэх; мөн (v) ХБИ-эд зориулсан дуудлагын шууд утас байгуулна.

**Бүтээгдэхүүн 3: Хүрээлэн буй орчны хүртээмжийг нэмэгдүүлэх.** Төслийн хүрээнд (i) хүрээлэн буй орчны (дэд бүтэц, тээвэр болон мэдээлэл) хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль, тогтоомжийг боловсруулж мөрдүүлэхэд оролцдог шийдвэр гаргагчид болон холбогдох байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх; (ii) хууль тогтоомжийн хэрэгжилт, даган мөрдүүлэх арга механизмд ХБИ-ийг түлхүү оролцуулах; мөн (iii) төлбөрийн чадварт нийцсэн хиймэл эрхтэн, туслах технологийн хүртээмжийг аймгийн түвшинд нэмэгдүүлнэ.

**Бүтээгдэхүүн 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх.** Төслийн хүрээнд (i) ХБИ-ийн тодорхой аж үйлдвэрийн салбаруудад ажиллах ур чадварыг бий болгох загвар боловсруулж нэвтрүүлэх, ХБИ-ийн хөдөлмөр зуучлалыг сайжруулах, (ii) ХБИ-дэд ердийн ажил эрхлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс тэдэнд ээлтэй аж ахуй нэгжүүдийг дэмжих, дэмжлэгт тогтолцоо бүрдүүлэх, мөн (iii) ХБИ-ийн ажил эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналтад ХБИ-ийн оролцоог нэмэгдүүлнэ.

**Бүтээгдэхүүн 5: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг хөгжүүлэх.** Төслийн хүрээнд (i) ХБИ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулж, тэдгээрт хандах хандлагыг өөрчлөх, (ii) ХБИ-д түлхүү чиглэсэн, санхүүгийн туслалцааг нэмэгдүүлэх халамжийн тогтолцоог бүрдүүлэх замаар ХБИ-д үйлчилгээ болон тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, (iii) үндэсний хөтөлбөрт стратегийн үнэлгээ хийх, (iv) хэрэгцээ болон боломжит нөөц бололцоонд үндэслэн Олон улсын үйл хөдлөлийн ангиллыг нэвтрүүлэх, (v) Үндэсний статистикийн хорооны тоо мэдээг хөгжлийн бэрхшээлтэй холбогдсон мэдээллийн эрэлттэй

уялдуулах, мөн (vi) ХБИ-ийг эрүүл мэндийн даатгалд бүх нийтээр хамруулна.

3. Төсөл нь ТХГА-д заасны дагуу Зөвлөх үйлчилгээ үзүүлэх болно.
4. Төсөл нь 2022 оны 4-р сарын 30-ны өдөр дуусгавар болно.

**ХАВСРАЛТ 2**

**Зээлийг эргэн төлөх хуваарь**

Төлбөр хийх хугацаа

Үндсэн өрийн төлбөр  
(Зээлжих тусгай эрхээр  
илэрхийлэгдсэн)\*

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

\* Төлбөр хийхэд Зээлийн журмын 3.04 болон 4.03 заалтыг баримтална.

### ХАВСРАЛТ 3

#### Зээлийн хөрөнгийн хуваарилалт, ашиглалт

##### Ерөнхий зүйл

1. Энэхүү Хавсралтад хавсаргасан хүснэгтэд зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлын ангилал болон зээлээс тэдгээр ангилал тус бүрт хуваарилсан санхүүжилтийн хэмжээг харуулсан болно (хавсралт “Хүснэгт”). (Энэхүү Хавсралтад дурдсан “ангилал” гэдэг нь Хүснэгт дэх “ангилал” эсвэл “дэд ангиллууд”-ыг илэрхийлнэ.)

##### Зээлийн данснаас зарцуулалт хийх нөхцөл

2. АХБ өөрөөр тохирсноос бусад тохиолдолд Хүснэгт дэх ангилал бүрийн зардлыг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхдээ тухайн заасан зориулалт болон Хүснэгтэд заасан хувь хэмжээг баримтална.

##### Хүүгийн шимтгэл

3. “Хүүгийн шимтгэл” гэх ангилалд хуваарилсан хөрөнгийг төсөл хэрэгжих хугацаанд зээлийн хүүгийн шимтгэлд зарцуулна. АХБ нь уг зээлийн шимтгэл, хариуцлагын төлбөр төлөгдөх хугацаа болмогц төлбөрийг төлөхөд шаардлагатай дүнг зээлийн данснаас зарлагдаж, Зээлдэгчийн өмнөөс өөртөө төлөх эрхтэй.

##### Дахин хуваарилалт

4. Зээлийн хөрөнгийн хуваарилалт, хүснэгтэд заасан санхүүжилтийн хувь хэмжээг үл харгалзан:

- (a) хэрэв аль нэг ангилалд хуваарилсан зээлийн хэмжээ нь тухайн ангиллын хүрээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй бол АХБ Зээлдэгчтэй зөвшилцөн: (i) өөр ангилалд хуваарилагдсан боловч бусад зардлыг санхүүжүүлэхэд ашиглагдахгүй гэж АХБ үзсэн хөрөнгөөс тухайн ангилалд дутагдаж байгаа санхүүжилтийг нөхөх хэмжээгээр дахин хуваарилна, (ii) хэрэв дахин хуваарилсан хөрөнгө нь хүрэлцэхгүй бол тухайн ангиллын хүрээнд хийгдэх бусад зарцуулалтыг үргэлжлүүлэх үүднээс хөрөнгө дутагдсан зардалд анх зарцуулахаар төсөвлөсөн хөрөнгийн хувь хэмжээг багасгана; мөн
- (b) хэрэв нэг ангилалд хуваарилсан хөрөнгө нь уг ангилалд шаардагдах зардлын хэмжээнээс илүү гарвал АХБ нь Зээлдэгчтэй зөвшилцөн энэхүү илүү гарсан санхүүжилтийг өөр ангилалд дахин хуваарилна.

##### Зарцуулалт хийх журам

5. АХБ өөрөөр тохирсноос бусад тохиолдолд зээлийн хөрөнгийг “Зээлийн зарцуулалтын гарын авлага”-ын дагуу зарцуулна.

Нөхөн санхүүжилт

6. Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө гэхдээ уг өдрөөс өмнө 12 сараас хэтрэхгүй хугацаанд гарсан ажил болон зөвлөх үйлчилгээ мөн зөвшөөрөгдсөн захиргааны зардалтай холбоотой зардлыг зээлийн данснаас санхүүжүүлж болох боловч санхүүжих зардлуудын нийт дүн энэхүү зээлийн нийт үнийн дүнгийн 20%-иас хэтрэхгүй болно.

## ХҮСНЭГТ

ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙН ХУВААРИЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТ				
Дугаар	Зориулалт	АХБ-наас санхүүжүүлэх хөрөнгийн нийт хэмжээ (Зээлжих тусгай эрх) [\$]		Зээлийн данснаас гаргах санхүүжилтийн хувь
		Ангилал	Дэд ангилал	
1	Ажил	[9,860,549]		Нийт нэхэмжилсэн зардлын 87.1%
2	Тоног төхөөрөмж (Бараа)	[3,786,000]		
2A	Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой тоног төхөөрөмж		[3,246,000]	Нийт нэхэмжилсэн зардлын 91.6%
2B	Тээврийн хэрэгсэл		[540,000]	Нийт нэхэмжилсэн зардлын 100%
3	Нийгмийн харилцаа холбоо болон чадавхыг бэхжүүлэлт, материал, төсөл удирдах нэгж ба урсгал зардал	[5,208,379]		Нийт нэхэмжилсэн зардлын 100%
4	Зөвлөх үйлчилгээ	[1,558,600]		
4A	Олон улсын		[942,200]	Нийт нэхэмжилсэн зардлын 97.9%
4B	Үндэсний		[616,400]	Нийт нэхэмжилсэн зардлын 93.9%
5	Хүүгийн төлбөр	[1,689,915]		Нийт үнийн дүнгийн 100%
6	Хуваарилагдаагүй	[2,896,557]		
	<b>Нийт</b>	<b>[25,000,000]</b>		

**ХАВСРАЛТ 4****Бараа, ажил болон зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагаа**Ерөнхий зүйл

1. Бараа, ажил болон зөвлөх үйлчилгээг Худалдан авах ажиллагааны журам болон Зөвлөх үйлчилгээний журмын дагуу тус тус худалдан авна.
2. Хэрвээ АХБ-тай өөрөөр тохироогүй тохиолдолд бараа, ажил болон зөвлөх үйлчилгээг дараах худалдан авах журам болон сонгон шалгаруулах арга ашиглан худалдан авна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан дэлгэрэнгүй зохицуулалт болон босго дүн гэх зэргийг эдгээр аргуудад хамааруулан хэрэглэх болно. Зээлдэгч нь худалдан авах ажиллагааны арга, шалгаруулалт болон босго үнийн дүнг зөвхөн АХБ-тай урьдчилан тохирсны үндсэн дээр өөрчилж болох ба уг өөрчлөлтүүдийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан тусгах үүрэгтэй.
3. Энэхүү зээлийн хэлэлцээрт өөрөөр тодорхойлоогүй бол энэ Хавсралтад ашигласан бүх нэр томъёо нь Худалдан авах ажиллагааны журам болон/эсхүл Зөвлөх үйлчилгээний журамд заасан утгыг илэрхийлнэ.

Бараа, ажил болон зөвлөх үйлчилгээ

4. Бараа болон ажлыг доор дурдсан худалдан авах ажиллагааны аргуудыг ашиглан худалдан авна.
  - (a) Олон улсын өрсөлдөөнт тендер шалгаруулалт;
  - (b) Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалт; мөн
  - (c) Харьцуулалтын арга

Дотоодын давуу эрх

5. Зээлдэгч нь олон улсын улсын өрсөлдөөнт тендерийн саналыг үнэлэхдээ Худалдан авах ажиллагааны журмын 2.55(а) болон 2.56-д заасны дагуу дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнд тодорхой давуу эрх олгох эрхтэй. Худалдан авах ажиллагааны журмыг сонгохдоо Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заагдсан зохицуулалт болон босго үнийн дүнг харгалзан үзнэ.

Дотоодын нээлттэй тендер

6. Зээлдэгч болон АХБ аливаа дотоодын нээлттэй тендер шалгаруулалтыг зарлахаас өмнө Зээлдэгчийн дотоодын нээлттэй тендер шалгаруулалтын журам нь Худалдан авах ажиллагааны журамтай нийцэж буй эсэхийг баталгаажуулна. Зээлдэгч, АХБ харилцан зөвшилцсөний үндсэн дээр уг журамд оруулсан аливаа өөрчлөлт, тодруулгыг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгана. Харилцан зөвшөөрсөн өөрчлөлт, тодруулгад хийх аливаа өөрчлөлт нь Зээлдэгч болон АХБ гагцхүү бичгээр зөвшөөрсөн тохиолдолд л хүчинтэй болно.

Гэрээ байгуулах эрх олгох нөхцөл

7. Зээлдэгч нь байгаль орчинд нөлөө үзүүлэх аливаа Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах эрхийг дараах нөхцөл бий болох хүртэл олгохгүй. Үүнд:

- (a) Зээлдэгчийн Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар БОАҮ-г эцэслэн батлуулж авсан; мөн
- (b) Зээлдэгч БОМТ-ний холбогдох заалтуудыг Ажил гүйцэтгэх гэрээнд тусгасан.

Зөвлөх үйлчилгээ

8. Зээлдэгч нь дараах дэд хэсэгт зааснаас бусад тохиолдолд Зөвлөх үйлчилгээнд чанар-үнэд суурилсан сонгон шалгаруулалтыг ашиглана.

9. Зээлдэгч нь АХБ-ны шаардлагад нийцэх зөвлөх шалгаруулан авах процедурын дагуу хувь хүн зөвлөхийг шалгаруулж авна.

Үйлдвэрлэлийн болон оюуны өмч

10. (a) АХБ-ны санхүүжилтээр худалдан авах бараа, үйлчилгээ (үүнд бусад бараа, үйлчилгээтэй хамт, эсхүл тусад нь нийлүүлсэн бүх төрлийн компьютерийн тоног төхөөрөмж, програм хангамж болон систем орох ба үүгээр хязгаарлагдахгүй) нь гуравдагч этгээдийн үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн аливаа эрхийг хөндөх буюу зөрчихгүй байхыг Зээлдэгч хариуцна.

(б) Зээлдэгч нь бараа, үйлчилгээ худалдан авах бүх гэрээнд энэхүү хэсгийн дэд хэсэг (a)-д дурдсан зүйлтэй холбоотой зохих мэдэгдэл, баталгаа болон шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч буюу нийлүүлэгчээс гарах хохирол барагдуулах баталгааг тусгасан байхыг хариуцна.

11. Зээлдэгч нь АХБ-наас санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээнд зохих мэдэгдэл, баталгаа болон шаардлагатай тохиолдолд зөвлөх үйлчилгээ нь гуравдагч этгээдийн үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн аливаа эрхийг хөндөх буюу зөрчихгүй байх талаар зөвлөхөөс гаргах хохирол барагдуулах баталгааг тусгасан байхыг хариуцна.

Худалдан авалтын шийдвэрийг АХБ-наас хянах

12. Зээлдэгч болон АХБ өөрөөр тохирч, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгайлан заагаагүй бол олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын дүнд байгуулсан худалдан авах ажиллагааны гэрээ болон зөвлөх үйлчилгээний гэрээг АХБ урьдчилан хянана.



## ХАВСРАЛТ 5

### Төслийн хэрэгжилт ба санхүүгийн асуудлууд

#### Хэрэгжүүлэлтийн зохицуулалт

1. Зээлдэгч болон Төслийн гүйцэтгэгч байгууллага нь төслийг ТХГА-д заасан нарийвчилсан зохицуулалтын дагуу хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэнэ. ТХГА-д оруулах аливаа өөрчлөлт нь зөвхөн Зээлдэгч болон АХБ баталсны дараа хүчин төгөлдөр болно. ТХГА болон энэхүү зээлийн хэлэлцээр хооронд ямар нэг зөрүү гарсан тохиолдолд зээлийн хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөнө.

#### Байгаль орчин

2. Зээлдэгч нь өөрөө болон Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан (а) Зээлдэгчийн байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны холбогдох хууль тогтоомж; (б) Байгаль орчны хамгаалал; (в) БОАУ, БОМТ-нд заасан бүхий л шаардлага, арга хэмжээ, мөн Хамгааллын хяналт шинжилгээний тайланд тусгасан аливаа зөрчил арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний дагуу төсөл болон төслийн барилга байгууламжийн бэлтгэл, дизайн, барилгын ажил, хэрэгжүүлэлт, ашиглалт болон ашиглалтаас гаргах үйл ажиллагааг явуулах үүрэг хүлээнэ.

#### Нутгийн уугуул иргэд ба албадан нүүлгэн шилжүүлэлт

3. Зээлдэгч нь төслөөс АХБ-ны ХБББ-т тусгасан нутгийн уугуул иргэд болон албадан нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл үзүүлэхгүй байхыг хариуцна. Төслөөс аливаа сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд, Зээлдэгч нь төслийг өөрийн улсын холбогдох хууль тогтоомж болон АХБ-ны ХБББ-ийг даган мөрдүүлэхэд шаардлагатай бүхий л алхмуудыг хийнэ.

#### Хамгааллын шаардлагуудыг хэрэгжүүлэх хүний болон санхүүгийн хүч нөөц

4. Зээлдэгч нь өөрөө болон Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан БОМТ-г бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв болон хүний нөөцөөр хангана.

#### Тендерийн бичиг баримт, ажил гүйцэтгэх гэрээнд тусгах хамгаалалтай холбоотой заалтууд

5. Зээлдэгч нь бүхий л тендерийн болон Барилгын ажлын гэрээнд гэрээлэгчдийн хүлээх дор дурдсан үүрэг бүхий заалтуудыг тусгах эсвэл Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан тусгуулна. Үүнд:

(а) БОАУ болон БОМТ-нд тусгагдсан гэрээлэгчтэй (барилгын үед иргэдэд үзүүлсэн нөлөөллийн хэмжээнд) холбоотой шаардлага, арга хэмжээ, мөн АХБ-тай шинээр тохиролцсон эсвэл Хамгааллын хяналт шинжилгээний тайланд тусгасан аливаа зөрчлийг арилгах эсвэл урьдчилан сэргийлэх арга хэмжээг дагаж мөрдөх;

(б) Эдгээр бүх байгаль орчин болон нийгмийн арга хэмжээнд төсөв гаргах;

(в) БОАУ болон БОМТ-нд тусгагдаагүй, төслийн барилга, хэрэгжүүлэлт болон үйл ажиллагааны үед гарах аливаа гэнэтийн байгаль орчны эрсдэл болон нөлөөллийн талаар Зээлдэгчид бичгээр мэдэгдэх;

(г) Материал тээвэрлэлт болон барилгын ажлын өмнөх зам, хөдөө аж ахуйн болон бусад дэд бүтцийн нөхцөл байдлыг хангалттай баримтжуулж, тэмдэглэх; мөн

(д) Зам харгуй, бусад орон нутгийн дэд бүтэц болон хөдөө аж ахуйн газрыг барилгын ажил дуусахад төслийн өмнөх шиг нөхцөлд сэргээн оруулах.

#### Хамгааллын мониторинг ба тайлагнал

6. Зээлдэгч нь өөрөө эсвэл Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан дараахыг гүйцэтгэнэ:

(а) БОМТ-нд хугацааг сунгаагүй байхаас бусад тохиолдолд АХБ-наас төслийн хаалтын тайланг гаргах хүртэл төслийн барилга болон хэрэгжилт мөн БОМТ-ний хэрэгжилтийн хугацаанд Байгаль орчны хамгаалал болон БОМТ-ний хэрэгжилт, даган мөрдөлтийн талаарх жилийн тайланг АХБ-нд ирүүлэх ба Байгаль орчны хамгааллын хүрээнд нөлөөлөлд өртсөн гэх хүмүүст уг тайлангийн холбогдох мэдээллийг тайланг хүргүүлмэгц ил болгох;

(б) БОАУ болон БОМТ-нд тусгагдаагүй, төслийн барилга, хэрэгжүүлэлт болон үйл ажиллагааны үед аливаа гэнэтийн байгаль орчны эрсдэл болон нөлөөлөл гарвал тэдгээр эрсдэл эсвэл нөлөөллийн нарийвчилсан тодорхойлолтыг санал болгож буй шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт ирүүлж, нэн даруй АХБ-инд мэдэгдэнэ;

(в) Нийгмийн мониторингийн ажлын хүрээнд цуглуулсан мэдээллийг баталгаажуулахын тулд мэргэжлийн бөгөөд туршлагатай гаднын нийгмийн хамгааллын шинжээчдийг АХБ-ны шаардлагад нийцэх сонгон шалгаруулалт болон ажлын даалгаврын тодорхойлолт ашиглан ажиллуулж, тэдгээр шинжээчдийн баталгаажуулах ажилд дэмжлэг үзүүлнэ; мөн

(г) БОМТ-нд заасан шаардлага, арга хэмжээг зөрчсөн эсвэл зөрчсөн байж болох тохиолдолд уг зөрчлүүдийн талаар олж мэдмэгцээ нэн даруй мэдэгдэнэ.

#### Хөдөлмөрийн стандарт, эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа

20. Зээлдэгч нь төслийн хэрэгжилтийн хугацаанд өөрийн орны үндсэн хөдөлмөрийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдүүлнэ. Зээлдэгч

нь төслийн хүрээнд АХБ-наас санхүүжүүлэх тендерийн баримт бичиг болон гэрээнд гэрээлэгчдэд дараах болон бусад шаардлагыг тусгана (а) Зээлдэгчийн холбогдох хөдөлмөрийн хууль тогтоомжийг дагаж мөрдөн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны холбогдох нормыг тусган хэрэгжүүлнэ; (б) хүүхдийн хөдөлмөр ашиглахгүй; (в) ажилчдыг хөдөлмөр эрхлэлт болон мэргэжлийн хувьд ялгаварлан гадуурхахгүй; (г) албадан хөдөлмөр ашиглахгүй; (д) эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр хийх эрхээр бүрэн хангах; мөн (е) төслийн гэрээлэгч байгууллагуудын ажилчид, төслийн ойр орчим амьдардаг орон нутгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүдэд бэлгийн замын халдварт өвчин, ДОХ/ХДХВ-ийн талаар мэдээлэл, мэдлэг тараах эсвэл үүнийг гүйцэтгэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага авч ажиллуулна.

8. Зээлдэгч нь дээрх 3-р хэсэгт заасан шаардлагуудын биелэлтэд хатуу хяналт тавьж, АХБ-инд тогтмол тайлан гаргана.

#### Жендэр ба хөгжил

9. Зээлдэгч нь (а) ЖҮАТ-г түүнд заасан нөхцөлийн дагуу хэрэгжүүлэх; (б) тендерийн баримт бичиг болон гэрээнд гүйцэтгэгчийн ЖҮАТ-нд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий заалтуудыг оруулах; (в) ЖҮАТ-г хэрэгжүүлэх хангалттай хөрөнгө нөөц хуваарилах; (г) жендэрийн хүрээнд хүрэх гол үр дүн болон үзүүлэлтийг хангахад гарсан ахиц гэх мэт ЖҮАТ-ний хэрэгжилтийн ахицад тогтмол хяналт тавьж, АХБ-инд тайлагнах; мөн (д) жендэрийн хүрээнд хүрэх гол үр дүн болоод хүрэх зүүлэлтүүдийг хангах ба үүнд дараах үзүүлэлтүүд орно (i) 2022 он гэхэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд болон ХБХ-тэй эхийн дор хаяж 45% нь төрийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байх; (ii) дуудлагын төвд ойролцоогоор 16 ажилтныг жендэрт чиглэгдсэн зөвлөгөө болон жендэрт суурилсан хүчирхийллийн зөвлөгөө өгөх үр чадварт сургах ба эдгээрийн дор хаяж 50% нь эмэгтэй ажилчид байна; (iii) 2022 он гэхэд ХБИ-ийн ажиллах хүчийг 5000 хүнээр нэмэгдүүлсэн байх ба эдгээрийн дор хаяж 40% нь эмэгтэйчүүд байна; мөн (iv) 45,000 орчим ХБИ-ийн асран хамгаалагчдад тэтгэмж болон тусламжийн үйлчилгээ үзүүлэх ба эдгээрийн дор хаяж 80% нь эмэгтэйчүүд байна.

#### Хамтран санхүүжүүлэх

10. Зээлдэгч нь төслийн хэрэгжилтийг хангах, төслийн барилга байгууламжийн үйл ажиллагаа болон засвар, үйлчилгээг хангахад шаардлагатай зээлийн хөрөнгөөс гадуурх санхүүжилт, барилга байгууламж, үйлчилгээ, газар болон бусад хөрөнгө нөөцийг хэрэгцээтэй үед яаралтай гаргана. Зээлдэгч нь төсөлд холбогдуулан гаргах уг санхүүжилт, барилга байгууламж, үйлчилгээ, газар болон бусад хөрөнгө нөөцтэйг харуулах АХБ-ны шаардлагад нийцсэн нотолгоог тус банкны хүсэлтийн дагуу даруй гаргаж өгнө.

11. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан *аймгийн* ХБИ-ийн хөгжил, сэргээн заслын төвүүд болон ХБИБ-ын хөдөлмөр эрхлэлтийн төвийн үйл ажиллагаанд шаардлагатай төсвийн санхүүжилтийг цаг тухайд нь гаргана.

12. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан ХБИБ-ыг гэрээлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх шууд утас болон мэдээллийн үйлчилгээнд шаардлагатай санхүүжилтийг гаргана. Үүнд дуудлагын удирдлагын төхөөрөмж болон мэдээллийн дата баазын сервер (тоног төхөөрөмж); үйлчилгээний менежер эсвэл сайн

дурын хянагч мөн дата баазын менежер (цалинтай); мөн халаалт, цахилгаан, мөн системийн засвар үйлчилгээг санхүүжүүлэх төсвийн татаас (урсгал зардал) тус тус орно.

13. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан төслийн хэрэгжилтийн үед санхүүжилт дутах тохиолдолд түүнийг нөхөх нэмэлт санхүүжилтийг гаргана.

#### Үйл ажиллагааны заалтууд

14. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс 24 сарын дотор ХБИБ-ын хөдөлмөр эрхлэлтийн төвийг Төслийн гүйцэтгэгч байгууллагын өмнөөс ажиллуулах нөхцөлийг хангах үүднээс АХБ-ны шаардлагад нийцэх ХБИБ-ын шинээр байгуулагдсан холбоо болон Төслийн гүйцэтгэгч байгууллага хооронд гэрээ байгуулуулна. Уг гэрээнд тухайн хөдөлмөр эрхлэлтийн төвийн зорилтууд, тэдгээртэй уялдсан гүйцэтгэлийн зорилтот үзүүлэлтүүд, Төслийн гүйцэтгэгч байгууллагаас тус төвд хуваарилах төсвийн хэмжээ гэх зэргийг тусгасан байна.

15. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан аймгийн ХБИ-ийн хөгжил, сэргээн заслын төв нэг бүр болон Үндэсний сэргээн заслын төвд ажиллах доор дурьдсан ажилчдыг авч ажиллуулж, тэдгээрийг төслийн хүрээнд шинээр боловсруулсан стандарт үйл ажиллагааны процедур болон сургалтын хөтөлбөрөөр сургасан байна. Үүнд:

(а) хүүхдийн үйлчилгээнд: хөгжлийн бэрхшээл хариуцсан гурван нийгмийн ажилтан, нэг хөдөлмөр засалч, нэг хөдөлгөөн засалч, нэг хэл засалч болон нэг согог заслын (orthopedic) мэргэжилтэн;

(б) насанд хүрэгчдийн үйлчилгээнд: хөгжлийн бэрхшээл хариуцсан гурван нийгмийн ажилтан, нэг хөдөлмөр засалч, нэг хөдөлгөөн засалч, нэг хэл засалч болон нэг согог заслын (orthopedic) мэргэжилтэн; мөн

(в) дээрх хоёр үйлчилгээнд: нэг угтах үйлчилгээний болон захиргааны туслах ажилтан, мөн нэг засвар үйлчилгээ болон хамгаалалтын ажилтан.

16. Засгийн газар нь Эрүүл мэндийн ямаар дамжуулан зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс 90 хоногийн дотор АХБ-ны шаардлагад нийцсэн ОУУХА-ын асуудлаарх салбар дундын ажлын хэсэг байгуулж үр дүнтэй ажиллуулж эхэлсэн байх ба уг ажлын хэсэг нь ОУУХА-ыг бодлого шийдвэрт тусгах, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний практикт нэвтрүүлэх, мөн эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн салбарын мэргэжлийн сургалтад нэвтрүүлэх замаар хэрэгжүүлсэн байна. ОУУХА-ын ажлын хэсгийн гишүүд нь дор хаяж Эрүүл мэндийн яам, Төслийн гүйцэтгэгч байгууллага, Боловсролын яам, анагаах ухаан болоод багшийн сургуулиуд мөн бусад сургалтын институци, ХБИБ-ууд мөн эрүүл мэнд, нийгэм хамгаалал болон боловсролын салбарын мэргэжлийн холбоод болон бусад байгууллагуудаас бүрдэнэ.

17. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан төслийн

удирдах хороо болон төслийн аливаа худалдан авах ажиллагааны шийдвэрийг хянах тендерийн үнэлгээний хороодод ХБИ-ийн төлөөллийг оролцуулна. Төслийн гүйцэтгэгч байгууллага нь дээрхи хороодод төлөөлөл болох хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийг бүхий л ХБИ, ХБХ болон тэдгээрийн гэр бүр, нэн ялангуяа төлөөлөл нь орхигдож ирсэн ХБИ (оюуны бэрхшээлтэй иргэн гэх мэт)-ийн төлөөлж чадах, тэдгээрийн төлөө тэмцдэг иргэд байхыг хариуцна.

18. Зээлдэгч нь Төслийн гүйцэтгэгч байгууллагаар дамжуулан зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор АХБ-ны шаардлагад нийцсэн гомдол, асуудал шийдвэрлэх ажлын хэсгийг байгуулж үр дүнтэй ажиллуулж эхэлсэн байх ба уг ажлын хэсэг нь төсөл, төслийн үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгч, төслийн хэрэгжилтийг хариуцсан аливаа этгээд төслийн хөрөнгийг буруугаар ашигласан, мөн жөндөр болон бусад хамгааллын зөрчилтэй холбоотой аливаа гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байхыг хариуцна.

#### Хориотой хөрөнгө оруулалтын жагсаалт

19. Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг Хамгааллын бодлогын баримт бичгийн Хавсралт 5-д заасан хориотой үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх үүргийг хангана.

#### Гомдол хянан шийдвэрлэх механизм

20. Зээлдэгч нь АХБ-ны шаардлагад нийцсэн БОМТ-ний дагуу хамгаалалтай холбоотой гарсан гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх тусгай механизмыг БОМТ-нд заасан хугацаанд ТХН дээр байгуулна.

#### Засаглал ба авлигатай тэмцэх

21. Зээлдэгч, Төслийн гүйцэтгэгч байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч байгуулагууд нь (а) АХБ-ны "Авилгатай тэмцэх бодлого" (1998 он, нэмэлт өөрчлөлтийн хамт)-ыг дагаж мөрдөх, мөн төсөлтэй холбоотой аливаа хээл хахууль, хуйвалдаан, луйвар эсхүл албадан шахалт бүхий ажиллагаа явагдсан гэх мэдээлэлд үндэслэн АХБ шууд эсвэл өөрийн төлөөлөгчөөрөө дамжуулан шалгалт хийх эрхтэйг хүлээн зөвшөөрөх; мөн (б) тухайн шалгалтын үед хамтран ажиллаж, түүнийг явуулж дуусгахад шаардлагатай бүхий л туслалцаагаар хангана.

22. Зээлдэгч, Төслийн гүйцэтгэгч байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч байгуулагууд нь АХБ-ны шаардлагад нийцсэн авилгын эсрэг заалтуудыг тендерийн баримт бичгүүд болон гэрээнд тусгах ба үүнд төсөл удирдагч болон хэрэгжүүлэгч агентлаг, гэрээт байгууллага, нийлүүлэгчид, зөвлөхүүд болон төсөлтэй холбоотойгоор үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагын данс, бүртгэлийг шалгах АХБ-ны эрхийг тусгасан заалт хамаарна.

